



ЭНЭРЭЛ ДЭЭД СУРГУУЛЬ

ЭЛСЭГЧДИЙН ХӨТӨЧ

Улаанбаатар

ГАРЧИГ

| | |
|---|----|
| 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ | 3 |
| 2. ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ | 7 |
| 3. ЭЛСЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА..... | 9 |
| 4. ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ШАЛГАРУУЛАЛТ | 10 |
| 5. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН, ХЭЛ ШИНЖЛЭЛ, УРАН ЗОХИОЛ, СЭТГҮҮЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ЭЛСЭГЧДЭЭС АВАХ МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ШАЛГАЛТ | 11 |
| 6. ОЮУТНААР ЭЛСЭХ ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВАХ | 12 |
| 7. БУСАД АСУУДАЛ..... | 13 |
| 8: СУРГАЛТАД БАГЦ ЦАГИЙГ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ..... | 28 |

Нэг. Ерөнхий зүйл**БШУСайдын 2013 оны 03 дугаарын 18 өдрийн А/79**

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 03 дугаар сарын 18–ны өдрийн А/79 дүгээр тушаалын хавсралт

/Энэ хавсралтад БСШУС-ын 2016-03-16-ны А/87, 2018 оны А/194 дугаар тушаалаар орсон нэмэлт, өөрчлөлтийг тусгав/

ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1 Өмчийн хэлбэр харгалзахгүй их сургууль, дээд сургууль, коллеж (цаашид “дээд боловсролын сургалтын байгууллага” гэх) –д оюутан элсүүлэхэд энэхүү журмыг баримтална. Тайлбар: Шашны боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад энэхүү журам хамаарахгүй.
- 1.2. Дээд боловсролын сургалтын байгууллага энэхүү журамд нийцүүлэн оюутан элсүүлэх сургуулийн журмаа боловсруулж, захирлын тушаалаар батлан мөрдүүлнэ. Дээд боловсролын сургалтын байгууллага оюутан элсүүлэх журамдаа дараах шаардлагыг заавал тусгасан байвал зохино. Үүнд:
 - 1.2.1.Элсэгчдэд тавих нийтлэг болон онцлог шаардлагууд;
 - 1.2.2.Оршин байгаа газраасаа өөр аймаг, хотоос оюутан хэрхэн элсүүлэх;
 - 1.2.3.Элсэх хүсэлтэй иргэний өргөдөл хүлээн авч шийдвэрлэх, хариу мэдэгдэх журам, бүрдүүлэх материал, энэхүү журмын дагуу эссе бичүүлэх бол түүнд тавих шаардлага;
 - 1.2.4.Шалгуулагчаас заавал өгөх ерөнхий шалгалт, ерөнхий шалгалтаас гадна нарийвчилсан нэмэлт

- авьяас чадварын шалгалт авах бол хэзээ, хаана, ямар шалгалт авах, шалгалтын хэлбэр, агуулга, бүтэц, хугацаа, дүгнэх зарчим;
- 1.2.5.Ерөнхий шалгалтад авсан байх босго оноо, хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлэх бол болзол, бүрдүүлэх нэмэлт материал;
- 1.2.6.Оюутан элсүүлэх мэргэжлийн чиглэлүүд, сургалтын хэлбэр, ямар шалгалт өгөх, элсэгчдийг шалгаруулах зарчим;
- 1.2.7.Ямар мэргэжлүүдийг нэг бүлэгт хамруулах, мэргэжил сонгуулах, тэнцсэн шалгуулагчдыг оюутнаар элсүүлэх журам;
- 1.2.8.Бүрэлдэхүүний болон харьяаллын ерөнхий боловсролын сургуулийн ахлах сургуулийг тухайн онд төгсөгчдөөс элсүүлэх зарчим;
- 1.2.9.Урьд нь дээд боловсрол эзэмшсэн хүнийг хэрхэн элсүүлэх журам, мэргэжлийн шаталсан сургалтаар дэвшин сурах зарчим;
- 1.2.10.Гадаадын оюутан элсүүлэх зарчим;
- 1.2.11.Оюутан элсүүлэхтэй холбогдсон маргаан, гомдол шийдвэрлэх журам;
- 1.2.12.Элсэлтийн шалгалтын комисс, түүний эрх, үүрэг;
- 1.2.13.Сургалтын төлбөр, түүнийг төлөх зарчим;
- 1.2.14.Тэнцсэн иргэн хичээлийн жил эхлэхэд сургуульдаа бүртгүүлэх хугацаа, бүртгүүлэхэд тавих нийтлэг шаардлага.
- 1.3. Оюутан элсүүлэх ажлыг зохион байгуулж буй дээд боловсролын сургалтын байгууллага, комисс үйл ажиллагаандаа “Боловсролын тухай”, “Дээд

боловсролын тухай” хуулиуд, энэхүү журам, сургуулийн элсэлтийн журмыг удирдлага болгоно.

- 1.4. Оюутан элсүүлэх ажлын гол зорилго нь шалгуулагчдын ерөнхий боловсролын түвшин, мэдлэг, чадвар, авьяасыг бодитойгоор үнэлж, цаашид амжилттай суралцах чадвартай хүмүүсийг шалгаруулан элсүүлэхэд оршино.
- 1.5. Оюутан элсүүлэх ажлыг дараах үе шаттай зохион байгуулна.
 - 1.5.1. Шалгуулагч энэхүү журмын 1.2.4-д заасан ерөнхий шалгалт өгнө.
 - 1.5.2. Элсэлтийн ерөнхий шалгалт өгч, зохих болзлыг хангасан иргэдийн хүсэлтийг дээд боловсролын сургалтын байгууллага хүлээн авч, өөрийн тогтоосон шалгуурыг бүрэн хангасан иргэнийг элсүүлнэ. Дээд боловсролын сургалтын байгууллага элсэлтийн ерөнхий шалгалтын онооноос гадна харгалзах өөрийн шалгуур (бүрэн дунд боловсролын үнэмлэхийн дүн, багш нарын тодорхойлолт, эссэ, авьяас чадварын шалгалт, ярилцлага)-ыг тодорхойлон мөрдөж болно. Шалгуулагч мэдлэг шалгах шалгалт нэмж өгөх, уг шалгалтын дүнг харгалзах шаардлагыг энэхүү шалгуурт тусгаж болохгүй. /Энэ хэсгийг БСШУСС-ын 2018 оны А/194-р тушаалаар өөрчлөн найруулсан/
- 1.6. Оюутан элсүүлэх үйл ажиллагаа нь ил тод, шударга, хүртээмжтэй, тэгш байдлыг хангасан байна.

- 1.7. Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн зар сурталчилгаа, үйл ажиллагаа нь үнэн зөв, цаг үеийн байдалд нийцсэн, ойлгомжтой байж, шалгуулагч бүрэн мэдээлэлтэйгээр сургууль, мэргэжлээ сонгох боломжийг хангасан байна.
- 1.8. Ерөнхий чиглэлээр эхэлж элсүүлээд сургалтын явцад нарийвчилсан мэргэжлийн чиглэлээ тогтоох нөхцөлтэйгөөр оюутан элсүүлж байгаа дээд боловсролын сургалтын байгууллага нь шалгуур, нөхцөлөө тодорхой томъёолох, сургалтын хэд дэх жилээс ямар мэргэжлийн чиглэл сонгох боломжтой талаар шалгуулагчдыг мэдээллээр хангах үүрэгтэй.
- 1.9. Дээд боловсролын сургалтын байгууллага нь оюутан элсүүлэх мэргэжил, хяналтын тоо, тухайн мэргэжлээр сурах норматив хугацаа, сургалтын төлбөр, заавал өгөх шалгалт болон шалгалтын оноо, дүнд тавих шаардлага зэрэг сургууль, мэргэжлээ сонгоход шаардлагатай мэдээллийг сургуулийн цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулна.
- 1.10. Техник тоног төхөөрөмж, программ хангамж, орчин бүрдсэн нөхцөлд ерөнхий шалгалт өгөх, мэргэжил сонгох шалгаруулалтад орох иргэнийг интернэтээр бүртгэж болно.
- 1.11. Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчдийн хангавал зохих энэхүү журмын 2.2-д заасан ерөнхий шалгалтын үндэсний хэмжээний босго оноог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтооно.

- 1.12. Дээд боловсролын сургалтын байгууллага нь элсэгч монгол хэл, бичгийн шалгалт болон ерөнхий шалгалтад авсан байх онооны босго тогтоож мөрдөнө. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон үндэсний хэмжээний босго оноог харгалзан сургуулийн оноог тогтооно.
- 1.13. Дээд боловсролтой иргэн хоёр дахь дээд боловсрол эзэмших хүсэлтэй бол дээд боловсролын сургалтын байгууллагын тогтоосон журмын дагуу элсэнэ. /Энэ хэсгийг БСШУСС-ын 2018 оны А/194-р тушаалаар хассан/
- 1.14. Олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий боловсролын хөтөлбөрийн шалгалт өгч зохих байгууллагаас гэрчилгээ авсан, энэ журмын 2.1-д нэмэлтээр заасан элсэлтийн ерөнхий шалгалтад хамрагдаагүй Монгол Улсын иргэн дээд боловсролын сургалтын байгууллагад элсэхэд энэхүү журмын 7.1.4 дэх хэсэгт заасныг баримтална. /Энэ хэсгийг БСШУСС-ын 2018 оны А/194-р тушаалаар нэмсэн/

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ

- 2.1. Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэх бүрэн дунд боловсролтой иргэн монгол хэл, бичгийн мэдлэг, чадварын шалгалт болон ерөнхий боловсролын түвшин, мэдлэг, чадварыг тогтоох зорилго бүхий элсэлтийн Ерөнхий шалгалт өгнө.
- 2.2. Элсэлтийн ерөнхий шалгалт нь монгол хэл, математик, нийгмийн тухай мэдлэг, Монгол Улсын түүх, англи хэл, орос хэл, хими, физик, биологи,

газарзүйн хичээлийн I (заавал судлах) ба II (гүнзгийрүүлж сонгон судлах) гэсэн ялгамжтай агуулгад үндэслэн бэлтгэсэн тестийн болон бусад хэлбэртэй байна. Монгол хэл, бичгийн шалгалтыг элсэлтийн ерөнхий шалгалт өгөх бүх иргэн заавал өгнө.

- 2.3. Элсэлтийн ерөнхий шалгалтыг хичээлийн жилд нэг удаа зохион байгуулна. Элсэлтийн ерөнхий шалгалт авах хугацааг “Боловсролын үнэлгээний төв” Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тогтооно. /2.2, 2.3 дахь хэсгийг БСШУСС-ын 2018 оны А/194-р тушаалаар өөрчлөн найруулсан/
- 2.4. Боловсролын үнэлгээний төв элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний түвшинд зохион байгуулна.
- 2.5. Элсэлтийн Ерөнхий шалгалтын дүнгийн тухай баримт бичиг түүнийг олгосон өдрөөс хойш 2 жил 6 сарын хугацаанд хүчинтэй байна.
- 2.6. Энэхүү журмын 2.2 ба 1.2.4-д заасан элсэлтийн ерөнхий шалгалтын хичээлүүдэд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн тохиолдолд түүнийг уг шийдвэр гарснаас хойш 6 сарын дараа мөрдөж эхэлнэ.
- 2.7. Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгч нь монгол хэл бичгийн шалгалтыг заавал өгсөн байна. Монгол хэл, бичгийн шалгалтыг жилд 2 удаа зохион байгуулах ба эхний шалгалтад бага оноо авсан шалгуулагч оноогоо ахиулах зорилгоор, хүндэтгэн үзэх шалтгаанаар эхний шалгалтад

хамрагдаж чадаагүй бол иргэн дараагийн шалгалтад орж болно.”

- 2.8. Элсэлтийн ерөнхий шалгалтыг ил тод, нээлттэй зохион байгуулах хүрээнд шалгалтын гүйцэтгэсэн ажлыг мэдээллийн технологийг ашиглан засалтыг шууд явуулж болно.”
- 2.9. Элсэлтийн ерөнхий шалгалтад шалгуулагч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн бол шалгалт өгөх нэмэлт анги танхим, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах бөгөөд суралцагчийн шалгалт өгөх өдөр, шалгалтын үргэлжлэх хугацааг сунгах зэрэг асуудлыг Боловсролын үнэлгээний төв хариуцан зохион байгуулж болно. /2.7, 2.8, 2.9 дэх хэсгийг БСШУСС-ын 2018 оны А/194-р тушаалаар нэмсэн/

ГУРАВ. ЭЛСЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

- 3.1. Дээд боловсролын сургалтын байгууллагад бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой иргэнийг элсүүлнэ.
- 3.2. Элсэгч нь энэхүү журмын 1.2.4-д заасан ерөнхий шалгалтыг өгч, 1.12-д заасан босго онооны шаардлагыг хангана.
- 3.3. Элсэгч нь мэргэжлийн онцлог, тухайн чиглэлээр суралцах сонирхол, авьяас, бэлтгэл сайтай иргэнийг элсүүлэх зорилгоор дээд боловсролын сургалтын байгууллагаас тавьсан шалгуурыг хангана.
- 3.4. Багш мэргэжлээр элсэгчдэд тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага тогтооно. Багш мэргэжлээр ерөнхий шалгалтад 500 ба түүнээс дээш оноо авсан шалгуулагчийг элсүүлнэ. /Энэ хэсгийг БШУны сайдын 2013 оны 4 сарын 19-ний өдрийн А/126 дугаар тушаалаар хассан

ДӨРӨВ. ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ШАЛГАРУУЛАЛТ

- 4.1. Дээд боловсролын сургалтын байгууллага элсэгчийн ерөнхий шалгалтын оноо, бусад шаардлагыг хангасан эсэхийг харгалзан элсүүлнэ.
- 4.2. Дээд боловсролын сургалтын байгууллага нь ерөнхий шалгалтад орсон шалгуулагчдыг шалгаруулан оюутнаар элсүүлэхэд баримтлах дэгийг бие даан баримтлан зохион байгуулна.
- 4.3. Дээд боловсролын сургалтын байгууллага нь оюутан элсүүлэх шалгаруулалтыг элсэлтийн ерөнхий шалгалтын дүн олон нийтэд зарласан өдрөөс эхлэн ажлын 10 өдөрт багтаан зохион байгуулж дууссан байна.”
- 4.4. Дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн суралцагчийг хөтөлбөр, мэргэжлээр суралцах мэдлэг, чадвартай болохыг тогтоож тухайн бүлэгт тохирох элсэлтийн ерөнхий шалгалтын хичээлийг сонгох ба ерөнхий шалгалтын хичээл нь 2-оос багагүй байна.”
- 4.5. Энэ журмын 2-т заасан элсэлтийн ерөнхий шалгалт өгч дээд боловсролын сургалтын байгууллагад элсэх болзол хангасан элсэгч өөрийн суралцах бэлтгэл (сурлага) авьяас чадвар, туршлага, хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлсэн эссэ

бичлэг бичиж элсэлтийн комисст заавал ирүүлж дүгнүүлсэн байна. /4.3, 4.4, 4.5 дэх хэсгийг БСШУСС-ын 2018 оны А/194-р тушаалаар нэмсэн/

ТАВ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН, ХЭЛ ШИНЖЛЭЛ, УРАН ЗОХИОЛ, СЭТГҮҮЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ЭЛСЭГЧДЭЭС АВАХ МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ШАЛГАЛТ

- 5.1 Их сургууль, дээд сургууль, коллежид сурган хүмүүжүүлэх ухаан, хэл шинжлэл, уран зохиол, сэтгүүл зүйн мэргэжлийн чиглэлээр элсэгчид нь монгол хэлний элсэлтийн ерөнхий шалгалтаас гадна монгол хэл, бичиг, уран зохиолын ур чадварын нарийвчилсан шалгалт заавал өгнө.
- 5.2 Нарийвчилсан шалгалтыг тухайн их сургууль, дээд сургууль коллеж нь бие даан зохион байгуулна. Сургууль нарийвчилсан шалгалтыг энэхүү журмын 1.5.2- т заасан шалгуурт нэмж оруулна.
- 5.3 Нарийвчилсан шалгалт нь дараах агуулгыг багтаасан байна:
 - Монгол хэл, бичгийн найруулга зүй (эссэ)
 - Уран зохиол (өөрийн зохиосон шүлэг, өгүүллийг танилцуулах, телевизийн киноны зохиол, хүүхэлдэйн киноны эх зохиолын төлөвлөгөө, санаа гаргах, бичсэн зохиол зэргийн аль нэг нь) - Монголын түүх
 - Монгол бичиг
 - Ярилцлага (өөрийгөө яруу тод илэрхийлэх, асуудалд шүүмжлэлтэй хандах зэрэг)

ЗУРГАА. ОЮУТНААР ЭЛСЭХ ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВАХ

- 6.1. Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцах хүсэлтэй иргэн өргөдөл /зохих загварын дагуу/ эссэ/тухайн хөтөлбөрөөр суралцах хүсэл, сонирхлоо илэрхийлсэн/ холбогдох баримт бичгийг тухайн байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлнэ. /Энэ хэсгийг БСШУСС-ын 2018 оны А/194-р тушаалаар өөрчлөн найруулсан/
- 6.2. Дээд боловсролын сургалтын байгууллага аймгаас оюутан элсүүлэх ажлыг орон нутагт нь дангаар болон хамтран зохион байгуулж болно.
 - 6.2.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу түүний эрх олгосон байгууллагаас баталсан аймгаас оюутан элсүүлэх хуваарь дээр уг аймагт оршин суугаа иргэн өрсөлдөх эрхтэй. Тухайн онд ерөнхий боловсролын сургууль төгссөн иргэн өөр аймаг, хотод оршин суух бүртгэлтэй хирнээ төгссөн сургууль нь орших аймгийн хуваарь дээр бүртгүүлэн сонгон шалгаруулалтад оролцож болно.

ДОЛОО. БУСАД АСУУДАЛ

- 7.1. Дээд боловсролын сургалтын байгууллагад дараах тохиолдолд иргэнийг элсэлтийн ерөнхий шалгалтгүй элсүүлэн суралцуулж болно. Үүнд:
- 7.1.1. Дээд боловсролтой иргэн хоёр дахь дээд боловсрол эзэмших;
- 7.1.2. Дипломын боловсролтой, Тусгай мэргэжлийн дунд сургуулийг төгссөн иргэн мэргэжлийнхээ дагуу бакалаврын хөтөлбөрт үндсэн болон цагийн сургалтад элсэх суралцагч;
- 7.1.3. 1 жилийн хөрвөх сургалтад хамрагдах суралцагч;
- 7.1.4. Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн, улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын оноог Боловсролын үнэлгээний төвөөр дүйцүүлэн тооцуулж, дүйцүүлсэн батламж авсан иргэн байх бөгөөд энэ нөхцөлийг хангасан их, дээд сургууль, коллежид элссэн оюутны мэдээллийг холбогдох журмын дагуу Боловсролын салбарын мэдээллийн системд оруулна.
- 7.1.5. 7.1.4-д заасан дүйцүүлэн тооцох аргачлалын журмыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Ерөнхий боловсролын бодлогын асуудал эрхэлсэн нэгжтэй зөвшилцөн Боловсролын үнэлгээний төвийн захирал батална.
- 7.1.6. Гадаад улсаас ижил түвшний дээд боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах; /7 дугаар зүйлийг БСШУСС-ын 2018 оны А/194-р тушаалаар нэмсэн/

БШУСайдын 2022 оны 04 сарын 22 өдрийн А/138



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/138

Улаанбаатар хот

Босго оноо тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/79 дүгээр тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам"-ын 1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Их, дээд сургууль, коллежид 2022-2023 оны хичээлийн жилд бакалаврын зэргийн хөтөлбөрт оюутан элсүүлэх ерөнхий шалгалтын үндэсний хэмжээний босго оноог их сургуульд 480, дээд сургуульд 440, коллежид 400, орон нутгийн их, дээд сургуульд 410 байхаар тус тус тогтоосугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг удирдлагаар хангаж ажиллахыг Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар /Х.Тамир/, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Боловсролын ерөнхий газар /Г.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Л.Ганбат/-д тус тус даалгасугай.

3. Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтэд босго оноог хангасан байдалд хяналт, шинжилгээ хийж дүнг 2022 оны 10 сард багтаан танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ч.Энх-Амгалан/-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны "Босго оноо тогтоох тухай" А/187 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН





БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН

ТУШААЛ

2021 оны 10 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар А/348

Улаанбаатар хот

ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 2 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3, 3.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь: 1. Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, дүйцүүлэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд баримтлах үлгэрчилсэн журмыг нэгдүгээр, "Түгээмэл хэрэглэгддэг дүнгийн нэмэлт тэмдэглэгээ, түүний тайлбар" /Хүснэгт 1/, "Бакалаврын хөтөлбөрийн ерөнхий суурийн хичээлд дүйцүүлэн тооцох Кембриджийн хөтөлбөрийн хичээл" /Хүснэгт 2/, "Түгээмэл хэрэглэгддэг багц цагийн харьцааны үзүүлэлт" /Хүснэгт 3/, "Гадаадын түгээмэл хэрэглэгддэг үнэлгээний системийг хөрвүүлэн тооцох аргачлал" /Хүснэгт 4/-ыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Үлгэрчилсэн журмыг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн дагаж мөрдөх, журамд нийцүүлэн холбогдох эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулж батлахыг төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежийн захирал нарт үүрэг болгосугай.

3. Журмыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын газар /С.Должин/-т даалгасугай.

САЙД Л.ЭНХ-АМГАЛАН

ЭДС-ийн элсэлтийн журмыг тус тус үндэслэн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулна.

Хоёр. Элсэлтийн үйл ажиллагааны зохион байгуулалт

Элсэлтийн үйл ажиллагааг дараах үе шатаар зохион байгуулна. Үүнд:

2.1. Элсэгчдэд мэдээлэл дамжуулах:

- Телевиз
- Радио
- Пэйж хуудас, фейсбүүк

2.2. Элсэгчдийг бүртгэх:

- 2.1.1. Цахим хуудсаар,
- 2.1.2. ЭДС-ийн ЭК-ийн нарийн бичиг
- 2.1.3. Орон нутагт томилолтоор ажилласан ЭДС-ийн ЭК-ийн гишүүн багш нар

2.3. Бүртгүүлэгчдийг эрэмбэлэх:

- 2.3.1 Мэргэжлийн хөтөлбөр,
- 2.3.2 Дамжаа,
- 2.3.3 Анги бүлгээр эрэмбэлэх /Хүснэгт/

2.4. Бүртгүүлэгчдийг мэдээллээр хангах: ЭДС-ийн “Элсэгчдийн хөтөч”- тэй танилцах

2.5. Суралцагчдыг баталгаажуулах:

- 2.5.1 ЭДС-ийн захирлын тушаалаар
- 2.5.2 Үүлэн программаар
- 2.5.3 БШУЯ-ны ДБУМ-ийн программаар

Гурав. Оюутан элсүүлэх журам

ЭНЭРЭЛ ДЭЭД СУРГУУЛЬД 2023-2023 оны хичээлийн жилд

ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 “Энэрэл” Дээд Сургууль/ цаашид ЭДС- гэнэ/-ийн 2022-2023 оны хичээлийн жилд оюутан элсүүлэхэд БШУ -ны Сайдын 2013 оны 03-р сарын 18-ны А/79 тоот тушаалаар батлагдсан “ Оюутан элсүүлэх журам”, БСШУС-ын сайдын 2018 оны А/195 тоот тушаал болон бусад холбогдох эрх зүйн акт болон энэхүү журмыг үндэслэн үйл ажиллагаандаа баримтлан ажиллана.
- 1.2 ЭДС-д элсэн суралцахаар хүсэлт гаргагч , элсэлтийн ажлыг удирдан зохион байгуулах элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.3 ЭДС-ийн элсэлтийн комисс нь / цаашид ЭК -гэнэ/ Улаанбаатар хотын Чингэлтэй Дүүргийн 13-р хорооны нутаг дэвсгэрт байрлах , өөрийн сургуулийн байрандаа болон хөдөө орон нутагт итгэмжлэгдсэн бие төлөөлөгчөөр дамжуулан элсэгчдийн хүсэлтийг хүлээн авах , бүртгэх, элсүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.4 ЭДС-ийн ЭК-ийг захирлын тушаалаар томилж, ажил үүргийн хуваарийг хавсралтаар баталж ажиллана.
- 1.5 ЭК- нь энэхүү журмыг баримтлан комиссын

гишүүдийн ажил үүргийн хуваарилалт, элсэлтийн үед баримтлах дэг журам, элсэхийг хүсэгчдийн материалыг шалгах болон өргөдөл гомдлыг' барагдуулах, элсэлтийн явцад хяналт тавих зэрэг элсэлттэй холбоотой үйл ажиллагааг зохицуулна.

- 1.6 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан зөвшөөрлийн дагуу өөрийн байгууллагын материаллаг бааз, тусгай зөвшөөрөлд заагдсан мэргэжлийн дагуу оюутан элсүүлнэ.
- 1.7 Энэхүү журам болон элсэлт авах мэргэжлийн хөтөлбөр , элсэлтийн ажлын зохион байгуулалттай холбоотой нэмэлт мэдээллийг ЭДС-ийн www.enerel.edu.mn веб хуудсанд байрлуулна.

ХОЁР: ЭЛСЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА :

- 2.1 ЭДС-д элсэгч нь бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой байх ба тухайн хөтөлбөрт харгалзах суурь хичээлээр тухайн онд элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн байна.
- 2.2 Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулах ерөнхий шалгалтыг энэхүү журмын 2.3-д заасан хичээлээр өгч тус сургуульд элсэх болзлыг хангасан байна.
- 2.3 ЭДС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэхийг хүсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад хими, биологи, математик, физик, нийгэм судлал, англи хэлний, монгол хэл хичээлүүдийн хамгийн өндөр оноотой 2 хичээлээр буюу 440 болон түүнээс дээш оноо авсан элсэхийг хүсэгчдийг бүртгэнэ.

- 2.4 ЭДС-ийн дипломын хөтөлбөрт элсэхийг хүсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад хими, биологи, математик, физик, нийгэм судлал, англи хэл, монгол хэлний хичээлүүдийн хамгийн өндөр оноотой 2 хичээлээр буюу 400 болон түүнээс дээш оноо авсан элсэхийг хүсэгчдийг бүртгэнэ.
- 2.5 Бакалаврын болон дипломын дээд боловсролтой иргэнийг элсэлтийн ерөнхий шалгалтгүйгээр элсүүлнэ.
- 2.6 Дипломын боловсролтой анагаахын мэргэжлийн сургууль төгссөн иргэн мэргэжлийнхээ дагуу шаталсан бакалаврын хөтөлбөрт элсэх бол ЭЕШ - гүй элсүүлнэ
- 2.7 Тухайн оны хичээлийн жилд сургалтын төлбөр 1 кредит үнэлгээ 110,000 төгрөг бөгөөд ЭДС-ийн суралцагчидтай хийх сургалтын гэрээг байгуулж, төлбөрийг сургуулийн **ХААН БАНК-5032551068** дансанд хийсэн тохиолдолд суралцах эрх баталгаажна.
- 2.8 ЭДС-ийн элсэгч нь оюутны сургалтын гэрээнд гарын үсэг зурснаар албан ёсоор сургуульд элссэнээр тооцно.

ЭНЭРЭЛ ДЭЭД СУРГУУЛЬ

| № | Элсүүлэх мэргэжил | Индекс | Дипломын зэрэг | Суралцах хугацаа | Элсэгчдийн боловсролын түвшин | Элсэлтийн ерөнхий шалгалт | Босго оноо |
|-----|---|---------|----------------|------------------|-------------------------------|--|--------------------------------|
| 1. | Эм зүйч | D091601 | Бакалавр | 5 жил | Бүрэн дунд | Хими,Биологи Математик, физик, нийгэм судлал, англи хэл, монгол хэл | БШУСайдын шийдвэр үндэслэнэ |
| 2. | Нийгмийн эрүүл мэнд судлалч, эрүүл ахуйч | D091801 | Бакалавр | 5 жил | | | |
| 3. | Сувилахуй | D091301 | Бакалавр | 4 жил | | | |
| 4. | Эх барихуй | D091308 | Бакалавр | 4 жил | | | |
| 5. | Эх барихуйн шаталсан бакалавр | D091308 | Бакалавр | 1 жил | Диплом | Анагаахын боловсрол эзэмшсэн байна | |
| 6. | Сувилахуйн шаталсан бакалавр | D091301 | Бакалавр | 1 жил | Диплом | | |
| 7. | Эм найруулагч | C091601 | Диплом | 3 жил | Бүрэн дунд | Хими, биологи,математик, физик, нийгэм судлал, англи хэл, монгол хэл | БШУСайдын шийдвэр үндэслэнэ. |
| 8. | Сувилагч | C091301 | Диплом | 3 жил | | | |
| 9. | Эх баригч | C091302 | Диплом | 3 жил | | | |
| 10. | Уламжлалт анагаахын сувилагч | C091701 | Диплом | 3 жил | | | |
| 11. | Дүрс оношилгооны техникч | C091202 | Диплом | 3 жил | | | |
| 12. | Эмнэлгийн тоног төхөөрөмж угсралт ашиглалтын техникч, электроникч | C091203 | Диплом | 3 жил | | | |

ГУРАВ: ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

- 3.1 Цахим хуудсаар бүртгүүлэхийг хүсэгчид тухайн оны 06-р сарын 27-ний өдрөөс тухайн оны 09-р сарын 15 өдрүүдэд <http://enerel.edu.mn/elseltanket.docx> хаягаас анкет татан авч info@enerel.edu.mn хаяг руу илгээн бүртгүүлэх эсвэл <http://www.enerel.edu.mn/dpk> хаягаар цахимаар бүртгүүлж болно.
- 3.2 ЭК- нь тухайн оны 06-р сарын 27-ноос, 09-р сарын 15 -ны хооронд элссэн элсэгчдийн жагсаалтыг гаргаж мэдээллийг сургууль дээр болон сургуулийн веб сайт <http://enerel.edu.mn/> дээр танилцуулна.
- 3.3 ЭДС-д ЭЕШ -ын оноог баримтлан оюутан элсүүлэх бөгөөд тухайн оны 09-р сарын 15-аас тухайн оны 10-р сарын 15-ний өдрүүдэд нэмэлт элсэлтийн бүртгэл явагдана.
- 3.4 Бүртгүүлэгч хэдэн ч хөтөлбөрт бүртгүүлж болох ба бүртгэлийн хураамж 30.000 төгрөг байна.
- 3.5 Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.
- 3.6 Тухайн мэргэжилд бүртгүүлэгчдийн ЭЕШ-ын онооны болзлыг хангасан элсэгчдэд ЭДС-д суралцах эрхийн бичиг томилолт олгоно.

ДӨРӨВ: ХӨНГӨЛӨЛТТЭЙ НӨХЦӨЛӨӨР ЭЛСҮҮЛЭХ :

- 4.1 2020-2021 оны хичээлийн жилд хими, биологийн олимпиадад улс, аймгийн 1-1У байр эзэлсэн, олон улсын олимпиадад шагналт байранд шалгарсан сурагчийг элсүүлэх ба төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх.

- 4.2 Анагаах ухааны их, дээд сургуульд хүний их эмч мэргэжлээр төгссөн , мэргэжил дээшлүүлсэн магистрт суралцсан, нарийн мэргэжил эзэмшсэн элсэгчийг Нийгмийн эрүүл мэнд судлалч эрүүл ахуйч, Эм зүйн -IV дамжаанд элсүүлнэ.
- 4.3 Анагаахын бусад мэргэжлээр бакалавр зэрэгтэй болон дипломын зэрэгтэй мэргэжилтэн ЭДС-ийн тусгай зөвшөөрөлд дурдагдсан мэргэжлүүдээр III дамжаанд элсүүлнэ.
- 4.4. Анагаахын бус их, дээд сургууль, коллеж төгссөн бакалаврын болон дипломын зэрэгтэй мэргэжилтэн ЭДС-ийн тусгай зөвшөөрөлд дурдагдсан мэргэжлүүдээр II дамжаанд элсүүлнэ.

А/ ТӨРӨӨС ОЛГОГДОЖ БУЙ ТЭТГЭЛЭГТ:

Сувилагч мэргэжлээр элсэгчдэд:

- Голч оноо 3.0 ба түүнээс дээш тохиолдолд -100%
- Голч оноо 2.8-3.0 байгаа тохиолдолд-70%

Б/ ОЮУТНЫ ХӨГЖЛИЙН ЗЭЭЛ:

➤ Сургалтын зээл / ажлын байранд гараад төлөх зээл/

С/ БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГААС БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ:

- Бүтэн өнчин
- Хагас өнчин
- Эцэг эхийн аль нэг нь хөгжлийн бэрхшээлтэй
- Элссэн суралцагч хөгжлийн бэрхшээлтэй зэрэг тохиолдолд бүрэн хамрагдана.

Д/ СУРАЛЦАХ ХУГАЦААНДАА СУРГУУЛИАС ОЛГОХ УРАМШУУЛАЛ :

- ОУ-ын тэмцээн уралдаанд 1-р байр эзэлсэн тохиолдолд 1 жилийн сургалтын төлбөрийг - 50%
- 4 улирал дараалан А үнэлгээтэй суралцвал сургалтын төлбөрийг -10%
- 6-8 улирал дараалан А үнэлгээтэй суралцвал сургалтын төлбөрийг -15%
- Шилдэг оюутанд үүсгэн байгуулагчийн тэтгэлэг олгоно.
- 1 гэр бүлээс тус сургуульд 2 оюутан сурдаг бол эхний хүүхдийн сургалтын төлбөрийг - 20%
- Ихэр хүүхдүүд суралцвал сургалтын төлбөрийг - 20%
- Төлбөрийн чадвар багатай өрхийн суралцагчийн төлбөрийг 2-р дамжаанаас эхлэн гэр бүлийн орлогынх нт бүрдэх боломжийг харгалзан тусгай гэрээгээр жилд 3-4 удаа хуваан төлөх боломж олгоно.

ТАВ. ЭЛСЭГЧДИЙН БҮРТГЭЛ БАТАЛГААЖУУЛАЛТ:

- 5.1 Шалгалтын дүнгээр болзол хангасан элсэгч тухайн оны 08-р сарын 15-25 -ны хооронд сургууль дээр биеэр ирж бүртгүүлэн суралцах гэрээ байгуулан ДБУМС-д бүртгүүлж баталгаажуулна.
- 5.2 Элсэгчдийн бичиг баримт нь зөрчилгүй байх шаардлагатай
- 5.3 Элсэгчид бүртгэлээ баталгаажуулахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

| д/д | Бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт |
|-----|--|
| 1 | Бүрэн дунд боловсролын гэрчилгээ түүнтэй адилтгах бичиг баримт эх хувиараа мөн нотариатаар баталгаажуулсан хуулбар |
| 2 | Сурагчийн хувийн хэрэг |
| 3 | Иргэний үнэмлэхийг нотариатаар баталгаажуулсан хуулбар |
| 4 | 3*4 хэмжээтэй 4 хувь цээж зураг |
| 5 | Сургалтын төлбөр төлсөн баримт |
| 6 | Эрүүл мэндийн дэвтрийн хуулбар |
| 7 | Эцэг эхийн иргэний үнэмлэхийн хуулбар |
| 8 | Сургуульд элсэхийг хүссэн өргөдөл / ЭДС-ийн |
| 9 | Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж |

5.4 Элсэлтийн бүртгэлээ баталгаажуулаагүй элсэгчийг суралцахаас татгалзсан гэж үзэн орон тоонд нөхөж элсэлт авна.

ЗУРГАА. ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВЧ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

6.1 Элсэлтийн явцад энэ журмыг зөрчсөн асуудал гарвал элсэгч нь өөрийн санал бодлыг ЭК-т тавина.

6.2 ЭК- нь тухай элсэгчийн санал гомдлыг хүлээн авч маргааныг элсэлтийн журам түүнтэй адилтгах эрх зүйн хүрээнд шийдвэрлэнэ.

6.3 ЭЕШ -тай холбоотой маргааныг ЭК хариуцахгүй болно.

6.4 Шилжих, чөлөө авах асуудлыг гэрээнд зааснаар ЭК шийднэ.

ДОЛОО.БУСАД

- 7.1 Цахим бүртгэл явагдаж байхад бүртгүүлэгчдэд зөвлөгөө өгөх үйл ажиллагааг сургуулийн байранд биечлэн болон info@enerel.edu.mn facebook, утас ашиглан явуулна. Мөн дэлгэрэнгүй мэдээллийг www.enerel.edu.mn сайтаас авах боломжтой.
- 7.2 ЭК -нь элсэлттэй холбоотой үйл ажиллагааг шударга явуулах, элсэгчдийг үнэн бодит мэдээллээр хангах үүрэгтэй бөгөөд ямар нэгэн байдлаар зохисгүй үйлдэл гаргасан бол ЭДС-ийн дотоод журмын холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээнэ.
- 7.3 Элсэгч нь элссэн хуваарь хүчингүй болгосон тохиолдолд сургалтын төлбөрийн 20%- ийг төлж бичиг баримтаа буцаан авна.

ЭДС-ИЙН ЭЛСЭЛТИЙН КОМИСС

Дөрөв. Нэгж хичээлийн хөтөлбөр сургалтын төлөвлөгөөнөөс авна

Шинээр элссэн суралцагчид сургалтын үйлчилгээний шаардлагын хүрээнд мэргэжлийн зориулалт тодорхойлолт, эзэмших мэргэжил ур чадвар, дадал, судлах хичээлийн жагсаалт тэдгээрийн багц цаг, хичээлийн залгамж холбоо зэргийг тусгасан мэдээллээр хангаж ажиллана.

Нэг. Суралцагчид нь дараах хэлбэрүүдээр суралцана. Үүнд

1. Сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн хичээлийн хуваарийн цахим болон танхимын сургалт
2. Ур чадвар дадлагын танхимын сургалт
3. Семинарын цахим болон танхимын сургалт
4. Үйлдвэрлэлийн дадлага
5. Бие даан суралцах
6. Орон нутгийн цахим болон танхимын сургалт

Хоёр. Суралцагчдын мэдлэг чадвар хандлагыг үнэлэх журмаар суралцагчдыг үнэлэх ба дараах хэлбэрүүдтэй байна. Үүнд:

1. Хичээлийн ирц 10 оноо
2. Бие даалт 20 оноо
3. Явцын үнэлгээ 40 оноо
4. Улирлын шалгалт 30 оноо
5. Төгсөлтийн төлөвлөгдсөн зорилготой эмнэл зүйн улсын 6 өртөө шалгалт зэрэг болно

Гурав. Суралцагчдын сургалтыг дэмжих үйлчилгээнд. Үүнд:

1. Оюутны алба
2. Чийрэгжүүлэлтийн өрөө
3. Мэргэжлийн хөтөлбөрийн ур чадварын танхим
4. Лаборатори кабинетууд
5. Сургалтын материаллаг бааз
6. Багаж, тоног төхөөрөмж, муляж, туслах хэрэгсэл
7. Ном, сурах бичиг гарын авлага хэрэглэгдэхүүн
8. Техник хэрэгсэл, цахим орчин үзүүлнэ

Дөрөв. Суралцагчдын нийтийн үйлчилгээ.

1. Номын сан
2. Нээлттэй номын сан
3. Уншлагын заал
4. Интернэт орчин
5. Спорт заал
6. Оюутны амрах бие даан ажиллах хэсэг
7. Дугуйлан клуб
8. Цайны газар
9. Оюутны дотуур байр
10. Жижиглэн худалдаа
11. Харуул хамгаалалтын үйлчилгээг үзүүлнэ

Тав. Энэрэл дээд сургуулийн элсэгчид нь элсэлтийн журам, сургалтын журамтай танилцаж

1. Сургалтын гэрээ хийх
2. Сургалтын төлбөр хийх
3. Оюутны код авах
4. Оюутны үнэмлэх авснаар ЭДС-ийн оюутан суралцагч болно.

Зургаа. Кредит дүйцүүлэн тооцох журам

НАЙМ: СУРГАЛТАД БАГЦ ЦАГИЙГ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 10 сарын 06-ны өдрийн А/348 тушаалын нэгдүгээр хавсралт “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд баримтлах үлгэрчилсэн журам”-ыг үндэслэн ЭДС-д элсэн суралцах эрх үүссэн гадаад, дотоодын их, дээд сургууль коллежид амжилттай судалсан хичээлийг шууд тооцох, дүйцүүлэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Коммисын бүрэлдэхүүн

ЭДС-ийн дээд болон техникийн боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг дүйцүүлэн тооцох комиссын бүрэлдэхүүнийг сургалтын бодлого зохицуулалтын газрын саналыг харгалзан үзэх ба эрдэм шинжилгээ инновацын албанаас, сургалтын бодлого зохицуулалтын багаас, удирдах зөвлөлөөс тус бүр нэг сонгогдсон 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр ерөнхий захирлын тушаалаар батлан, томилж ажиллуулна.

Гурав. Коммисын ажиллах хугацаа

БШУСайдын А/348 тушаалын нэгдүгээр хавсралтын 2.2 заалтад заасан намрын улиралд багц цагийг дүйцүүлэх комисс ажиллаж суралцагч тус бүрийн

өмнөх боловсролын баримт бичигтэй танилцаж, дүн шинжилгээ хийж, багц цаг дүйцүүлэх комиссоос гаргасан шийдвэрийг захирлын тушаалаар баталж, шийдвэрт тусгагдсан сургалтын үйл ажиллагааг тэнхимийн эрхлэгч нар өвөл, зуны сургалтаар зохион байгуулан ажиллана.

3.1 Тухайн хичээлийн жилд багц цаг дүйцүүлэх комиссын ажиллах цагийн хуваарийг ЭДС-ийн захирлаар батлуулж, цахим хэлбэрээр 7 хоногийн өмнө мэдэгдэнэ.

3.2 Тухайн жилийн элсэн суралцагсдын материалыг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногт дүн шинжилгээ хийж шийдвэр гаргаж, ЭДС-ийн захирлын тушаалаар батлуулан ажиллана.

3.3 Багц цаг дүйцүүлэх комиссын гаргасан шийдвэрийн сургалтын үйл ажиллагааг өвөл, зуны сургалтаар нөхөлт хичээлийн хуваарьт тусгаж суралцагсдыг хамруулан ажиллахыг тэнхимийн эрхлэгч хариуцан ажиллана

Дөрөв. Комисст ирүүлэх баримт бичгийн жагсаалт

4.1 Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж төгссөн бакалаврын болон дипломын боловсролын дипломын хуулбарыг EMongolia лавлагаа болон эх хувиар

4.2 Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежоос шилжиж ирсэн суралцагсдын баталгаажсан дүнгийн тодорхойлолт

4.3 ЭДС-д элссэн захирлын тушаал

4.4 Давхар эзэмшсэн мэргэжлийн бакалаврын болон дипломын боловсролын дипломын хуулбарыг EMongolia лавлагаа болон эх хувиар

- 4.5 Магистр, докторын хөтөлбөрийг дүүргэсэн диплом эх хувиар
- 4.6 Ахисан түвшний мэргэжлийн диплом эх хувиар
- 4.7 Багц цаг дүйцүүлэх хүснэгт
- 4.8 Хувийн өргөдөл зэргийг тус тус багц цаг дүйцүүлэх комисст тэнхмээр дамжуулан хүлээлгэн өгнө.

Тав. Багц цаг ба хичээл дүйцүүлэгчдэд тавигдах шаардлага

- 5.1 Багц цаг дүйцүүлэгч нь ЭДС-ийн аль нэг мэргэжлийн хөтөлбөрт суралцагч байж элсэлтийн тушаалд орсон байх
- 5.2 Өмнөх дипломын боловсролоор доктор, магистр, бакалаврын, дипломын зэрэгтэй байх
- 5.3 ХНХЯ, БШУЯ-наас зөвшөөрсөн 1 жилийн сургалтын хөтөлбөрөөр төгссөн, туслах сувилагч мэргэжлийн үнэмлэхтэй төгсөгч байх
- 5.4 Дипломд тавигдсан /тооцов/ үнэлгээг 70С-ээр тооцно.
- 5.5 Дотоодын Их, дээд сургууль, коллежоос шилжин ирж суралцаж буй суралцагсад нь БШУЯ- ны ДБУМС-д бүртгэлтэй байх
- 5.6 Дотоодын их, дээд сургууль, коллежоос шилжин ирж суралцагсад нь тухайн сургуулийнхаа СБЗГазар ба сургалтын албаны тамгатай хэвлэмэл хуудсан дээр дүнгийн тодорхойлолт авсан байх
- 5.7 Гадаадаас шилжин ирж суралцагсад нь апостильд бүртгүүлж, бичиг баримтыг орчуулж нотариатаар батлуулах
- 5.8 ЭДС-ийн тусгай зөвшөөрөлд заасан тухайн сургалтын хөтөлбөрөөр суралцах хүсэлтээ өгсөн байх

Зургаа. Багц цаг ба хичээл дүйцүүлэх зарчим

- 6.1 БШУЯ-ны А/348 тушаалын нэгдүгээр хавсралтын агуулгад тулгуурласан байх
- 6.2 ЭДС-ийн сургалтын журмын агуулгатай уялдсан байх
- 6.3 Сургалтын үйл ажиллагаанд хэрэгжихүйц агуулгатай байх
- 6.4 Үр дүнг тооцож, хянаж үнэлэх тогтолцоотой байх
- 6.5 Өвөл, зуны хичээл нөхөлтийн цахим, танхимын сургалтын үйл ажиллагаанд сургалтын алба хяналт тавьж, хяналт үнэлгээний алба дүгнэлт гарган ажиллана

Долоо. Багц цаг дүйцүүлэн тооцох комиссын үйл ажиллагааны удирдамж

- 7.1 БШУЯ-ны сайдын А/348 тушаалын нэгдүгээр хавсралт, ЭДС-ийн бакалаврын болон дипломын батлагдсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, ЭДС-ийн багц цаг дүйцүүлэх комиссын ажиллах журмыг удирдлага болгоно
- 7.2 Өмнөх боловсролын докторын, магистрын, бакалаврын болон дипломын зэргийн баримт бичгийн суралцахуйн дүнг үндэслэл болгоно
- 7.3 Бусад их, дээд сургууль, коллежоос шилжин ирж суралцагсдын албан ёсны дүнгийн тодорхойлолтыг үндэслэл болгоно
- 7.4 Багц цаг дүйцүүлэхэд өмнөх боловсролын үндсэн эх дипломыг үндэслэл болгоно
- 7.5 Багц цаг дүйцүүлэх комисс нь үйл ажиллагаанаас 7 хоногийн өмнө тэнхимүүдээс шаардлагатай материалыг авч, суралцаж буй мэргэжлийн хөтөлбөр,

дамжаа, групп, овог, нэр, төгссөн сургууль, шилжиж ирсэн сургууль зэргийн мэдээллийг боловсруулах бэлтгэл ажлаа хангана

7.6 Багц цаг дүйцүүлэн тооцох үйл ажиллагааны төлөвлөгөөг комисс хуралдаж, захирлын тушаалаар батлуулан ажиллана

7.7 БСШУЯ Сайдын 2014 оны 04 сарын 28 өдрийн А/174 тоот тушаалын 2.2.1, 3.2- р заалтуудыг үндэслэж ерөнхий суурь хичээлийн нийтээр заавал судлах хичээлийн нийт 12 кредитийг агуулгаар дүйцүүлэн суралцуулж болно

7.8 Эрүүл мэндийн боловсрол эзэмшсэн докторын, магистрын, бакалаврын, мэргэшсэн мэргэжлийн дипломуудын суралцахуйн үр дүнгийн ерөнхий суурийн, мэргэжлийн суурийн, мэргэшүүлэх хичээлүүдийн агуулгын давхцалтай, багц цагийн шууд дүйцүүлэлт 60- 70% бол ЭДС-ийн сонгогдсон хөтөлбөрийн төгсөлтийн өмнөх дамжаанаас суралцуулан тухайн мэргэжлийн хөтөлбөрийн мэргэшүүлэх хичээлүүдийг хавар, намрын улиралд судлуулан, зарим нөхөлт хичээлийг өвөл, зуны улиралд судлуулан багц цагийг тооцно

7.9 Эрүүл мэндийн боловсрол эзэмшсэн бакалаврын болон С дипломын зэрэгтэй мэргэжилтэнг суралцахуйн үр дүнгийн ерөнхий суурийн, мэргэжлийн суурийн хичээлүүдийн агуулгын давхцалтай, багц цагийн шууд дүйцүүлэлт 50-60% бол ЭДС-ийн сонгогдсон хөтөлбөрийн 3 дамжаанаас суралцуулан тухайн мэргэжлийн мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдийг намар, хаврын улиралд судлуулах, зарим

нөхөл хичээлийг өвөл зуны улиралд судлуулан багц цагийг тооцно /4.12/

7.10 Бусад шинжлэх ухаанаар боловсрол эзэмшсэн мэргэжилтэнг мэргэжлийн зэргээс үл хамааран ерөнхий суурийн хичээлийн агуулгын давхцалыг харгалзан шууд дүйцүүлэх багц цаг 20-30% бол ЭДС-ийн сонгогдсон хөтөлбөрийн 2 дамжаанаас суралцуулан Тухайн мэргэжлийн ерөнхий суурийн, мэргэжлийн суурийн, мэргэшүүлэх нэгж хичээлүүдийг судлуулан, нөхөлт хичээлийг өвөл, зуны улиралд судлуулан багц цагийг тооцно.

7.11 Ижил түвшний хөтөлбөрөөр суралцагсдын шилжилт хөдөлгөөнийг тухайн мэргэжлийн хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцуулна.

7.12 Ижил бус хөтөлбөрөөр суралцагсад шилжин суралцах тохиолдолд ерөнхий суурийн, мэргэжлийн суурийн хичээлийн агуулгын давхцалыг харгалзан багц цагийг шууд тооцох ба ЭДС-ын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн тохирох дамжаанд үргэлжлүүлэн суралцуулна.

7.13 Гадаадын их дээд сургууль, коллежид судалсан багц цагийг тооцохдоо БШУЯ-ны сайдын А/348 тушаалын нэгдүгээр хавсралтын 4.13; 4.14; 4.17 заалтуудыг үндэслэл болгоно

7.14 Нөхөлт хичээлийг цахим контент болон бие даан суралцах хэлбэрээр багц цагийг тооцож болно

7.15 Богино хугацааны сургалт, түр сургалт, кредитийн сургалт, мэргэжлийн сертификат зэрэг нь багц цаг тооцох эх баримт бичигт тооцогдохгүй

Найм. Багц цаг тооцох хүснэгт

- 8.1 Багц цаг тооцох хүснэгтэд оюутны овог, нэр, суралцаж буй мэргэжил, индекс, дамжаа, групп, элссэн огноо, элсэлтийн тушаалын дугаар зэргийг тэмдэглэнэ
- 8.2 Тухайн хөтөлбөрийн ерөнхий суурийн, мэргэжлийн суурийн, мэргэшүүлэх нэгж хичээлүүдийн нэр, багц цагийг тусгана.
- 8.3 Хөтөлбөрийн нэгж хичээлийн дүйцүүлэлтийг БШУЯ-ны сайдын А/348 тушаалын 4.19, 4.20, 4.21 заалтуудыг тусгасан хүснэгттэй байх ба багц цагийн шууд дүйцүүлэх, агуулгаар дүйцүүлэх, нөхөн судалж дүйцүүлэх хүснэгтийн хэлбэртэй байна.
- 8.4 Багц цаг тооцох хүснэгтийг ЭДС –ийн гүйцэтгэх захирлаар батлуулж, тамга даруулах ба комисс гарын үсгээ зурж баталгаажуулна
- 8.5 Хүснэгтэд хар өнгийн балаар багц цаг, үнэлгээний үсгэн, тоон утгыг бичих

Ес. Багц цаг тооцох үнэлгээ

- 9.1 БШУЯ-ны сайдын А/348 тушаалын нэгдүгээр хавсралтын 4.24 заалтыг үндэслэн 1 багц цагт ноогдох төлбөрийн хэмжээг ЭДС-ийн УЗ –өөр батлуулан ажиллана
- 9.2 Багц цагийн дүйцүүлэлтийн төлбөрийг ЭДС-ийн төрийн банкны тоот дансанд хийнэ.
- 9.3 Багц цагийн төлбөр тушаагч нь овог, нэр, мэргэжил, дамжаа, групп, регистр, утасны дугаарыг заавал тодорхой бичсэн байна.

9.4 1 багц цагт ноогдох төлбөрийг тухайн хичээлийн жилд УЗ хурлаар батлуулж тогтоолыг үндэслэж тооцох ба засвар хийхийг хориглоно.

9.5 Нэгдсэн хүснэгтэд багц цаг дүйцүүлэгчдийн төлбөрийн хэмжээг хүн тус бүр дээр тогтоож, ЭДС-ийн гүйцэтгэх захирлаар батлуулан санхүүгийн албанд хүргүүлнэ

9.6 Санхүүгийн албанаас багц цагийн төлбөрийн тооцоо хийгдсэн суралцагсдын нэрсийг сургалтын албанд хүргүүлснээр X CLOUD программд нөхөн судлах эрх нээгдэнэ.

9.7 ЭДС-ийн батлагдсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан онол, дадлага, семинар, лабораторийн, бие даалтын багц цагаар нөхөлт сургалтыг зохион байгуулна.

9.8 Санхүүгийн албанаас тухайн жилд хуримтлагдсан багц цагийн дүнг УЗ-д танилцуулж ажиллана

Арав. Багц цаг тооцох комиссын үйл ажиллагаанд тавих хяналт үнэлгээ

10.1 ЭДС-ийн хяналт үнэлгээ чанарын албанаас тухайн жилийн багц цагийн тооцох хүснэгтэд хяналт үнэлгээг хийж ажиллана

10.2 Хяналт үнэлгээ чанарын албанаас гарсан үнэлгээний дүнг УЗ-д тайлагнаж ажиллана

Холбоо барих

Веб сайт: www.enerel.edu.mn

Цахим шуудан: info@enerel.edu.mn

Харилцах утас: 89980895,
88046875, 11-357484

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 13-р хороо, Хайлаастын-45, Энэрэл дээд сургуулийн байр (17-р сургуулийн автобусны буудал)

